



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 16 өдөр

Дугаар А/426

Мөрөн сум

Арга хэмжээ зохион байгуулах,
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Их хурлын 2022 оны 36 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 424 дүгээр тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/59 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөн, Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/59 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд “Хөвсгөл-Органик мах, Органик бүтээгдэхүүн, Намрын ногоон өдөр” арга хэмжээг 2024 оны 09 дугаар сарын 19, 20, 21-ны өдрүүдэд Мөрөн суманд зохион байгуулсугай.

2. Тус арга хэмжээг зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг хавсралтаар байгуулсугай.

3. Тус арга хэмжээнд холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг өргөн хүрээтэй хамруулж, оролцохыг сумдын засаг дарга нарт, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах, бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (М.Хуягбаатар)-т, арга зүйн дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа)-т, санхүү төрийн сангийн хэлтэс (Б.Базар)-т нарт тус тус даалгасугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга (Э.Улам-Өсөх)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Захирамж2024

6712011280

Аймгийн Засаг даргын 2024 оны 08
дугаар сарын /6.- ны өдрийн /4.4.26
дугаар захирамжийн хавсралт

**“ХӨВСГӨЛ-ОРГАНИК МАХ, ОРГАНИК БҮТЭЭГДЭХҮҮН,
НАМРЫН НОГООН ӨДРҮҮД” АРГА ХЭМЖЭЭГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ**

Ажлын хэсгийн ахлагч: М.Хуягбаатар (Аймгийн Засаг даргын орлогч дарга)

Гишүүдэд: Б.Оюунтуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө
оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
Л.Ариунаа (Мал эмнэлгийн газрын дарга)

П.Мөнхжаргал (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

Л.Батцэцэг (Аймгийн Соёл урлагийн газрын дарга)

Ж.Даваадамдин (Аймгийн Хөгжимт драмын театрын дарга)

Д.Батцоож (Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга)

Б.Өнөрбат (Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга)

Б.Очирбат (Биеийн тамир спортын газрын дарга)

Б.Сарантуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэвлэлийн
ажилтан)

Ц.Нацагдорж (Шинэ Мөрөн худалдааны төв ХХК-ны захирал)

Д.Гэрэлтуяа (ХАҮТ-ын Хөвсгөл аймаг дахь танхимын дарга)

Л.Оюун-Эрдэнэ (Аймгийн тогоочдын холбооны тэргүүн)

Сумдын Засаг дарга нар

Ү.Дамдинсүрэн (Мал амьтны бүртгэл, мэдээллийн, үндэсний
холбооны захирал) тохиролцсоноор

Л.Тунгалаг (Эс-Эф-Си-Эс ХХК гүйцэтгэх захирал)

Нарийн бичгийн дарга: Я.Эрхэмбаяр (Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын
дарга)

-----oOo-----